

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Ерөнхий боловсролын
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/98/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2024.02.05	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Баян ташаагийн эх аудит ХХК-ийн захирал Т.Хоролсүрэн Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/78

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Жаргалант сумын Ерөнхий болосролын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор аймгийн Жаргалант сумын Ерөнхий болосролын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан мэдээлэл хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Чиглэл батлах тухай" 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу багш, байгууллагын гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээгээр III индексд үнэлэгдэж 24039.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 15625.3 мянган төгрөгийг багш ажилчдад урамшуулалаар олгож, менежментийн зардалд 8413.6 мянган төгрөгийн урамшуулал авч хичээлийн байрны камержуулалтанд 43789.0 мянган төгрөг, багш ажилтны эрүүл мэндийн үзлэг

5020292

оношлогооны зардалд 4034.6 мянга төгрөгийг зарцуулахаар хамт олны хурлаар хэлэлцэн зарцуулсан.

Мөн 219,215.4 мянган төгрөгийн барилга, байгууламж актлагдаж, машин тоног төхөөрөмж 24,148.4 мянган төгрөгийн хөрөнгө актлагдаж, 37,144.7 мянган төгрөгийн төсвийн болон хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн байна. Мөн 4,625.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил актлагдаж, төсвийн болон хөрөнгө оруулалтаар 9,919.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгджээ.

Аудитын гол асуудал

Тайлант онд улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 314,283.9 мянган төгрөгөөр өссөн нь “Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмсэн, мөн БШУ-ны сайдын 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/170, 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/494 тоот тушаалуудаар төсөвт хөтөлбөр арга хэмжээ нэмсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Жаргалант сумын Ерөнхий боловсролын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 арга хэмжээний хүрээнд 14 зорилт хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 93.5 хувийн биелэлттэй ажиллаж, дээд газраас 92.1 хувь гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains some illegible text and a date. The signature is a stylized cursive script.

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	156,441,144.80	271,653,067.12
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	24,379,869.00	130,493,073.52
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	24,379,869.00	130,493,073.52
3121	Төгрөг	24,379,869.00	130,493,073.52
31211	Төрийн сангийн харилцах	24,379,869.00	130,493,073.52
33	АВЛАГА	433,775.00	433,775.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	433,775.00	433,775.00
35	БАРАА МАТЕРИАЛ	131,627,500.80	140,726,218.60
351	Түүхий эд материал	9,961,640.00	9,485,340.00
35110	Тусгай зориулалттай материал	7,826,940.00	7,826,940.00
35130	Эм боох материал	2,134,700.00	1,658,400.00
354	Хангамжийн материал	109,765,860.80	131,240,878.60
35410	Бичиг хэргийн материал	980,700.00	812,700.00
35420	Аж ахуйн материал	81,657,097.24	92,634,109.59
35440	Түлш, шагах төслөх материал	1,280,000.00	1,200,000.00
35450	Барилгын засварын материал	12,532,600.00	9,820,600.00
35470	Бусад хангамжийн материал	13,315,463.56	26,773,469.01
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,484,713,044.13	1,457,762,620.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,484,713,044.13	1,457,762,620.75
392	Биет хөрөнгө	1,452,088,419.09	1,419,746,037.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,498,935,769.10	1,279,720,369.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-318,857,538.39	-124,652,403.87
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	368,603,197.13	381,599,457.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	-180,745,384.13	-192,019,222.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,910,721.95	125,204,358.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-80,736,462.92	-82,782,329.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	4,035,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-112,086.11
39217	Ном	44,978,116.35	28,752,795.00
393	Биет бус хөрөнгө	32,624,625.04	38,016,583.39
39301	Програм хангамж	425,000.00	5,925,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-184,374.96	-860,416.61
39303	Бусад биет бус хөрөнгө	32,384,000.00	32,952,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,641,154,188.93	1,729,415,687.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,641,094,688.93	1,729,415,687.87
51	Засгийн газрын хувь оролцоо	1,641,094,688.93	1,729,415,687.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	492,188,069.70	492,188,069.70
51101	Өмч: - төрийн	492,188,069.70	492,188,069.70
512	Хуримтлагдсан үр дүн	64,264,684.39	152,585,683.33
51210	Өмнөх үеийн үр дүн	64,264,684.39	64,264,684.39
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	88,320,998.94

БНА-2024/98/НА-СТА-ТШЗ

**Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,084,641,934.84	1,084,641,934.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,641,154,188.93	1,729,415,687.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,690,856,735.56	1,671,608,620.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	295,679,487.56	58,436,520.45
120	Нийтлэг татварын бус орлого	295,348,748.56	58,436,520.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,491,000.00	19,386,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,260,700.00	2,282,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,230,300.00	17,103,300.00
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	226,944,048.00	1,613,172,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,482,517,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,482,517,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	158,604,000.00	130,655,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	158,604,000.00	130,655,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,444,071,626.13	1,566,532,300.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,425,206,626.13	1,554,632,300.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,289,570,388.13	1,484,387,558.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	883,925,449.00	1,027,818,478.00
210101	Үндсэн цалин	807,811,128.00	976,869,777.00
210104	Урамшуулал	35,512,362.00	50,948,701.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,648,641.00	128,683,274.00
210201	Тэтгэврийн даатгал	70,713,467.00	89,429,842.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,937,749.00	9,208,734.00
210203	ҮОМШО-ний даатгал	7,111,722.00	7,363,125.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,716,883.00	1,810,601.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,168,820.00	20,870,972.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,497,601.00	127,674,473.10
210301	Гэрэл, цахилгаан	9,997,601.00	11,089,473.60
210302	Түлш, халаалт	103,050,000.00	116,584,999.50
2104	Хангамж, бараа материалын зардал	59,990,589.00	41,642,732.65
210401	Бичиг хэрэг	7,284,950.00	10,153,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,986,200.00	6,354,330.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,413,950.00	22,869,787.00
210408	Бараа материал акаланы зардал	7,905,489.00	2,265,615.65
2105	Нормативт зардал	49,772,570.00	57,498,760.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,226,150.00	717,730.00
210502	Хоол, хүнс	46,546,420.00	56,781,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,147,400.00	5,187,700.00
210604	Урсгал засвар	6,147,400.00	5,187,700.00
2107	Томилолт, зочны зардал	314,600.00	1,913,200.00

БНА-2024/98/НА-СТА-ТШЗ

**Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210702	Дотоод албан томилолт	314,600.00	1,913,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,060,500.00	6,170,033.48
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,060,500.00	6,170,033.48
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,213,038.13	87,798,907.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,937,885.00	19,907,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,275,153.13	67,891,907.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,636,238.00	70,244,741.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	134,413,976.00	69,859,215.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,563,495.00	54,233,865.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,510,433.00	15,625,350.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	385,526.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	385,526.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,865,000.00	11,900,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,865,000.00	11,900,000.00
223001	Бусад хөрөнгө	18,865,000.00	11,900,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	246,785,109.43	105,076,320.29
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	16,755,321.35
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	16,755,321.35
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-16,755,321.35
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	246,785,109.43	88,320,998.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,411,503,987.00	1,632,558,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,326,739.00	19,386,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,996,000.00	19,386,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,491,000.00	19,386,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,260,700.00	2,282,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,230,300.00	17,103,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,395,177,248.00	1,613,172,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,482,517,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,482,517,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	158,604,000.00	130,655,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	158,604,000.00	130,655,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,347,189,478.00	1,488,116,090.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,347,189,478.00	1,488,116,090.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,211,553,240.00	1,417,871,348.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	883,972,158.00	1,027,818,478.00
210101	Үндсэн цалин	646,927,334.00	672,222,816.00
210102	Нэмэгдэл	180,052,700.00	304,646,961.00

БНА-2024/98/НА-СТА-ТШЗ



**Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210104	Урамшуулал	18,523,400.00	50,948,701.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,926,926.00	128,683,274.00
210201	Тэтгэврийн даатгал	75,566,670.00	89,429,842.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,932,368.00	9,208,734.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,137,219.00	7,363,125.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,786,094.00	1,810,601.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,504,575.00	20,870,972.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,192,101.00	128,272,473.10
210301	Гэрэл, цахилгаан	9,997,601.00	11,089,473.60
210302	Түлш, халаалт	102,744,500.00	116,564,499.50
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	618,500.00
2105	Нормативт зардал	46,075,420.00	56,776,830.00
210502	Хоол, хүнс	46,075,420.00	56,776,830.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,700,000.00	1,997,000.00
210604	Урсгал засвар	1,700,000.00	1,997,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,821,200.00	10,205,733.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,760,700.00	2,282,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,060,500.00	7,923,033.48
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,865,435.00	64,117,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,734,735.00	52,099,760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,130,700.00	12,017,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,636,238.00	70,244,741.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	134,413,976.00	69,859,215.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,563,495.00	54,233,865.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,510,433.00	15,625,350.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	385,526.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	385,526.90
213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	64,314,509.00	144,442,009.52
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	39,934,640.00	38,328,805.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,934,640.00	38,328,805.00
2200	Дотоод эх үүсвэрээр	39,934,640.00	38,328,805.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	39,934,640.00	38,328,805.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-39,934,640.00	-38,328,805.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	24,379,869.00	106,113,204.52
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	24,379,869.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,379,869.00	130,493,073.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	--

БНА-2024/98/НА-СТА-ТШЗ



**Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	492,188,069.70	1,084,641,934.84	64,264,684.39	1,641,094,688.9 3
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	492,188,069.70	1,084,641,934.84	64,264,684.39	1,641,094,688.9 3
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	492,188,069.70	1,084,641,934.84	64,264,684.39	1,641,094,688.9 3
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	88,320,998.94	88,320,998.94
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	492,188,069.70	1,084,641,934.84	152,585,683.33	1,729,415,687.8 7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,630,274,100.00	1,526,059,368.58	104,214,731.4	93.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,630,274,100.00	1,526,059,368.58	104,214,731.4	93.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,442,406,900.00	1,456,200,153.58	-13,793,253.6	101.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,128,562,800.00	1,027,818,478.00	100,744,322.0	91.1
210101	Үндсэн цалин	763,860,200.00	672,222,816.00	91,637,384.0	88.0
210102	Нэмэгдэл	310,314,200.00	304,646,961.00	5,667,239.0	98.2
210104	Урамшуулал	54,388,400.00	50,948,701.00	3,439,699.0	93.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,070,200.00	128,683,274.00	12,386,926.0	91.2
210201	Тэтгэврийн даатгал	95,927,700.00	89,429,842.00	6,497,858.0	93.2
210202	Тэтгэмжийн даатгал	11,285,600.00	9,208,734.00	2,076,866.0	81.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,028,400.00	7,363,125.00	1,665,275.0	81.6
210204	Ажилгүйдлийн даатгал	2,257,200.00	1,810,601.00	446,599.0	80.2
210205	Эрүүл мэндийн даатгал	22,571,300.00	20,870,972.00	1,700,328.0	92.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	128,272,473.10	-128,272,473.1	-100.0
210301	Гэрэл, цахилгаан	00.00	11,089,473.60	-11,089,473.6	-100.0
210302	Түлш, халаалт	00.00	116,564,499.50	-116,564,499.5	-100.0
210303	Цэвэр, бохир ус	00.00	618,500.00	-618,500.0	-100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	400,000.00	400,000.00	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	400,000.00	0.0	100.0

БНА-2024/98/НА-СТА-ТШЗ



**Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2105	Нормативт зардал	59,781,500.00	56,776,830.00	3,004,670.0	95.0
210502	Хоол, хүнс	59,781,500.00	56,776,830.00	3,004,670.0	95.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,997,000.00	-1,997,000.0	-100.0
210604	Урсгал засвар	00.00	1,997,000.00	-1,997,000.0	-100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,295,700.00	10,205,733.48	89,966.5	99.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,282,700.00	2,282,700.00	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,013,000.00	7,923,033.48	89,966.5	98.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102296700.00	102046365.00	250,335.0	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,277,200.00	90,028,565.00	248,635.0	99.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,019,500.00	12,017,800.00	1,700.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83008600.00	69859215.00	13,149,385.0	84.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,008,600.00	69,859,215.00	13,149,385.0	84.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	67,383,200.00	54,233,865.00	13,149,335.0	80.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,625,400.00	15,625,350.00	50.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮ ЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,525,415,500.00	1,630,274,100.00	-104,858,600.0	106.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,482,517,100.00	1,482,517,100.00	0.0	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,482,517,100.00	1,482,517,100.00	0.0	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	130,655,000.0	130,655,000.00	-130,655,000.0	-100.0
132001	Орон нутгийн төсвөөс	130,655,000.0	130,655,000.00	-130,655,000.0	-100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	42,898,400.00	13,352,000.00	29,546,400.0	31.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,270,000.00	13,352,000.00	2,918,000.0	82.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	24,379,869.00	-24,379,869.0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	130,493,073.52	-130,493,073.5	

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	57.00	57.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	40.00	40.00	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	0.0	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жаргалант сумын Ерөнхий боловсролын зорилго нь “Боловсролын хүрээмж чанар, үр өгөөжийг тасралтгүй дээшлүүлдэг, иргэдэд нээлттэй, хүүхдэд ээлтэй, эх байгальдаа хайртай, хөгжих тэмүүлэлтэй, багш ажилтан, суралцагчид бүхий ёс зүйтэй, эрүүл аж төрөх дадал хэвшилтэй хамт олон байна” гэж дэвшүүлжээ.

Тус байгууллага нь дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Амжилттай суралцъя.
- Илүү төлөвшсөн нэгэн байя.
- Соёлоор гангаръя.
- Эрүүл чийрэг Монгол хүн
- Оролцъё, хамтаръя

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс шинээр мөрдөгдөж эхэлсэн.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын Ерөнхий боловсролын 2023 оны оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88,261.5 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	24,379.8	130,493.0	106,113.2
Авлага	433.8	433.8	0.0
Бараа материал	131,627.5	140,726.2	9,098.7
Үндсэн хөрөнгө	1,484,713.0	1,457,762.6	-26,950.4
Нийт хөрөнгө	1,641,154.2	1,729,415.7	88,261.5
Өглөг	59.5	0.0	-59.5
Засгийн газрын хувь оролцоо	492,188.0	492,188.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	64,264.7	152,585.7	88,321.0

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,084,641.9	1,084,641.9	0.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1.641,154.2	1,729,415.7	88,261.5

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна.

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 106,11352 мянган төгрөгөөр өссөн гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжиж байгаатай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 140,726.2 мянган төгрөг болж 9,098.7 мянган төгрөгөөр өссөн 159,959.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 19,682.5 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдхүүн үнэ төлбөргүй хүлээн авсан, 168,277.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,457,762.6 мянган төгрөг болж 26,950.4 мянган төгрөгөөр буурсан нь худалдаж авсан үндсэн хөрөнгө 38,328.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 19,368.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/08 тоот тогтоолоор барилга байгууламжаас 1960 оны ашиглалтанд орсон 1992 оноос хойш ашиглах боломжгүй болох нь мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гарсан хичээлийн байр 219,215.4 мянган төгрөгийн өртөг бүхий барилгыг акталж, машин тоног төхөөрөмжөөс 24,148.4 мянган төгрөгийн, тавилга эд хогшилоос 4,625.3 мянган төгрөгийн, номын фондоос 16,755.3 мянган төгрөгийн хөрөнгийг тус акталж даснаас хассан байна. Тайланд онд үндсэн хөрөнгийн элэгдэл 67,891.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн 152,585.7 мянган төгрөг болж 88,320.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,503,602.4 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтийг 21,085.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,482,517.1 мянган

төгрөгөөр шинэчлэн баталсан нь “Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалинг нэмсэн, “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг өөрчлөх тухай” Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 8 дугаар тогтоолыг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн хүрээнд 14 арга хэмжээг санхүүжүүлэх зардлын эх үүсвэрийг 1,482,517.1 мянган, орон нутгийн төсвөөс 130,655.0 мянган, төгрөгийг тус тус бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,482,517.1 мянган, орон нутгийн төсвөөс 130,655.0 мянган, үндсэн үйл ажиллагаанаас 13,352.0 мянган, урд оны үлдэгдлээс 24,379.9 мянган төгрөгөөр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,526,444.9 мянган төгрөг буюу 93.6 хувьтай, баталсан төсвөөс зарцуулагдаагүй үлдэгдэл 130,493.0 мянган төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71601	Ерөнхий боловсрол	1,549,795.4	1,526,059.4	23,736.0	98.5
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,325,716.6	1,327,517.0	1,800.4)	100.1
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	141,070.2	128,683.2	12,387.0	91.2
83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал	83,008.6	69,859.2	13,149.4	84.2

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 108,048.7 мянган төгрөг худалдан авах төлөвлөгөөний дагуу 96,322.7 мянган, худалдан авах төлөвлөгөөнд тусгаагүй бичиг хэрэг, бусад хангамжийн материалыг 120,765.3 мянган, нийт 217,088.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Үүнд үдийн цай хөтөлбөр арга хэмжээнд 68,502.8 мянган төгрөгөөр харьцуулалтын тендерийн аргаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Бадрах азийн гэгээ ХХК шалгарч 56,776.8, төгрөгийн гүйтэлгэлтэй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасны дагуу цахим дэлгүүрээс 19,744.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөл, арга хэмжээнд 1,549,795.4 мянган төгрөгийг тусгаж баталснаас, гүйцэтгэлээр 1,526,059.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хүүхдэд ээлтэй орчин төсөл хөтөлбөрийн хүрээнд 19,744.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс гэрээгээр, тендерийн харьцуулалтын аргаар 56,776.8 мянган төгрөгөөр, 38,793.5 мянган төгрөгийн 2 багц хөрөнгийг шууд худалдан авалтын аргаар тус тус худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян ташаагийн эх аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Ч.Чимгээ, захирал Т.Хоролсүрэн нар, дараагийн шатны хяналтыг аудитын ахлах аудитор М.Алтантуяа, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян ташаагийн эх аудит ХХК-д 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн үр дүнгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 1,616,220.0 мянган төгрөгийн 1.0 хувиар буюу 16,162.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн БНА-2024/98/НА-СТА-ТШЗ

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 11,313.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхгүй арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин хөлс нэмэгдэл урамшуулалд 100,744.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын зардлуудад 12,386.9 мянган, нормативт зардалд 3,004.7 мянган, бусад урсгал шилжүүлэгийн зардалд 13,149.4 мянган төгрөгийн зардалуудыг хэмнэн улсын төсөвт 130,493.1 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус сургууль нь “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг мөрдөж мэдээллийг хугацаанд нь тогтмол хугацаанд нь бүрэн байршуулж ирсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар ямар нэгэн зөрчил илэрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн /

Өмнөх аудитаар өгсөн 4,635.7 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 28,111.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 45,049.4 мянган төгрөгийг 6 зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	4,635.7	3	4,635.7	100.0
Албан шаардлага	2	28,111.9	2	28,111.9	100.0
Зөвлөмж	6	45,049.4	6	45,049.4	100.0
Нийт дүн	11	77,797.0	11	77,797.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц зүйл байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй

Тус сургууль нь үйл ажиллагааныхаа чиглэлийн дауу байгууллагын хуулийн хүрээнд болон санхүүгийн зарчмын хувьд хууль, дүрэм, журмыг зөрчөөгүй 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг болон материаллаг бус алдаа, зөрчил илэрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөх санал хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.